



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/84

Хажуу шинэ ус

Хөдөө аж ахуйн салбар болон төв, суурин газрын
2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын
бэлтгэл хангах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын засгийн газрын 2024 оны "Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" 28 дугаар тогтоол, аймгийн засаг даргын А/563 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай", 2024-2025 оны аймгийн Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, ажлын явцад хяналт тавих, хэрэгжилтийг тооцох үүрэг бүхий ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

2.Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг 2024 оны 10 дугаар сарын 10-ны дотор хангаж, тайлан мэдээг 10 дугаар сарын 15-ны дотор, төв суурин газрын бэлтгэл ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны дотор тус тус хангаж хөдөө аж ахуйн мэргэжилтэнд ирүүлэхийг, Багийн засаг дарга гарт үүрэг болгосугай.

3.Засгийн газрын тогтоол, албан даалгаврыг хэрэгжүүлэх, ажил зохион байгуулах, ажлын явцад хяналт тавих, шалгуур үзүүлэлтийн дагуу хүлээн авах ажлыг 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор зохион байгуулахыг Засаг даргын орлогч (Б.Даваасүрэн)-д даалгасугай.

ДАРГА



Т.АРИУНАА

482401084

Засаг даргын 2024 оны...
сарын 11-ний өдрийн 1124 тоот
захирамжийн 1 дүгээр хавсралт

Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт , хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, ажлын явцад хяналт тавих, хэрэгжилтийг тооцох үүрэг бүхий ажлын бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Даваасүрэн	(Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга:	Д.Сарангэрэл	(ХААТ-ийн мэргэжилтэн)
Гишүүд:	Н.Ганбат	(Санхүү албаны дарга)
	А.Бямбадорж	(Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч)
	Ц.Мөнхсайхан	(Ус цаг уур орчны төвийн эрхлэгч)
	Б.Өлзийбат	(Улсын нөөцийн нярав)
	Б.Мөнхдэлгэр	(1 дүгээр багийн Засаг дарга)
	М.Амарзаяа	(2 дугаар багийн Засаг дарга)

Засаг даргын 2024 оны 09
сарын 11-ний өдрийн 1184 тоот
захирамжийн 2 дугаар хавсралт

Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсгийн
бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Даваасүрэн	(Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга:	П.Отгонжаргал	(Цэцэрлэгийн эрхлэгч)
Гишүүд:	Н.Долгорсүрэн	(Эрүүл мэндийн төвийн эрхлэгч)
	Т.Уранчимэг	(Сургуулийн захирал)
	Э.Ванчиндорж	(Хэсгийн төлөөлөгч)
	М.Ганбуд	(Соёлын төвийн эрхлэгч)
	Д.Билгүүн	(Ган-Илч ХХК-ийн эрхлэгч)
	М.Найдан	(Шуурхай үйлчилгээний техникч)
	Ц.Мөнхсайхан	(Ус цаг уур өртөөний техникч)
	Б.Өлзийбат	(Улсын нөөцийн нярав)
	Л.Батбаатар	(4 дүгээр багийн Засаг дарга)